



ДУНДГОВЬ АЙМАГ  
САЙНЦАГААН СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 2/54

Мандалговь

Г Арга хэмжээ зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "А", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.6, аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн А/94 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын хил залгаа сумдад малын гоц халдварт шүлхий өвчний гаралт буурахгүй байгаа, хотын төвийн ногоон бүсийг хамгаалахтай холбогдуулан иргэдийн тэжээвэр үхрийг хотын төвөөс 2018 оны 03 сарын 13-наас 03 сарын 20-ны дотор гаргасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллан, хэрэгжилт үр дүнг Засаг даргад 2018 оны 03 сарын 21-нд танилцуулахыг Хот тохижуулах газрын дарга /Д.Мөнхцоож/, Мал үржлийн хяналтын улсын байцаагч /Р.Булгантамир/, Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Ж.Миеэсүрэн/ холбогдох багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГОТОХ